



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/194

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 264 дүгээр тогтоолоор 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласны дагуу "МИАТ" ТӨХК-ийн зүгээс шинэ төрлийн агаарын хөлөг /CRJ-200/-аар орон нутгийн 9 чиглэлд тогтмол нислэг үйлдэхтэй холбогдуулан "Алтай", "Мөрөн", "Өлгий", "Дэглий цагаан", "Гурвансайхан", "Баянхонгор", "Ховд" нисэх буудлуудын аэродромын элементүүдийн хучилтын даацыг шинэчлэн тодорхойлох, тогтоох үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга

Н.Батсайхан

(Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга)

Гишүүд:

П.Сүхболд

(Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч)

Э.Мөнх-Эрдэнэ

(Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газрын аэродромын мэргэжилтэн)

Г.Уламбаяр /Зөвшилцсөнөөр/

("Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн аэродромын хэсгийн ашиглалтын инженер)

Нарийн бичгийн дарга:

С.Булганцэрэн
("Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлын
аэродромын хэсгийн дарга)

2.Ажлын хэсгийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулж, 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөрт багтаан ажиллахыг ажлын хэсэг (Н.Батсайхан)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газар (Ч.Одгэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА